



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАЛААЛТЫН ЗАРДЛЫН
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:ХОА-2023/44-20-ШТА-ГА

*Халаалтын талбайн хэмжилтийг бодитой хийж, гэрээний
үүргийн биелэлтийг дүгнэн ажилласнаар төсөв хэмнэх боломж
байна.*

Ховд хот
2023 оны 11 сар

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 70432545 Цахим хаяг: narantuuld@audit.gov.mn

Аудитор: А.Нарандэлгэр

Цахим хаяг: narandelgera@audit.gov.mn

Аудитор: Ц.Азаяа

Цахим хаяг: azzayats@audit.gov.mn

Аудитор: Н.Батжаргал

Цахим хаяг: batjargaln@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёог	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл	4

Бүлэг 1. Халаалтын зардлыг бодитой төлөвлөж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээг шинэчлэх, гэрээний хэрэгжилтийг дүгнэн ажиллах шаардлагатай байна.	4
---	---

БҮЛЭГ 2. Халаалтын зардалд дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлснээр 826.0 сая төгрөгийн төсвийн хэмнэлт хийх боломжтой байна.	11
---	----

Дүгнэлт:	16
----------	----

Зөвлөмж	17
---------	----

Саналд өгсөн тайлбар	19
----------------------	----

Холбогдох байгууллагын санал	19
------------------------------	----

Хавсралтууд	20
-------------	----

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЭХЗЗ	Эрчим хүчний зохицуулах зөвлөл
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Сумдын сургуулийн дотуур байрны илүү төлсөн халаалтын зардал	19
Хавсралт2	Дулаан халаалтын батлагдсан төсөв, гэрээний дүнгийн харьцуулсан судалгаа	20
Хавсралт3	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үнэ тарифын судалгаа	21

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/04 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	“Төсөвт байгууллагын халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: • Төсөвт байгууллагуудын халаалтын зардлыг хууль журмын дагуу үндэслэлтэй төлөвлөсөн эсэх? • Халаалтын зардлыг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулж, дотоод хяналт хэрэгжүүлсэн эсэх?
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс, Эрчим хүчний зохицуулах зөвлөл, дулаанаар хангагч 12 байгууллага, орон нутгийн төсвийн байгууллагууд хамрагдаж тэдгээрийн ажлын төлөвлөгөө тайлан, төсөв, тооцоо барилгын халаалтын эзлэхүүн, төсвийн байгууллагуудын 2021-2023 онд дулаан хангагч байгууллагатай хийсэн гэрээ, тооцоо нийлсэн акт, санхүүгийн баримт бичиг, үйл ажиллагааны үр дүн, холбогдох бусад материалуудаас авсан мэдээ, тайлан бусад материалд тулгуурлан гүйцэтгэлийн аудитыг хийв. Хөдөөгийн 12 суманд томилолтоор ажиллаж, халаалтын үйлчилгээний чанарын талаарх асуудлыг 2037 иргэнээс санал асуулга авч аудитад ашиглалаа.
Аудитын хязгаарлалт	Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээ байгуулсан зарим аж ахуйн нэгжүүдийн ажлын зураг, төсөв, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн нотлох баримт байхгүй байсан тул хэрэгжилтийг дүгнэх боломжгүй байна.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх аудитын арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдаж, аудитын менежер А.Цэцэгсүрэн чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нарантуул, аудитор А.Нарандэлгэр, Ц.Аззаяа, Н.Батжаргал нар гүйцэтгэв. Аудитыг 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 20-ний хугацаанд хэрэгжүүлж, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан тэргүүлэх аудиторов тушаалаар баталгаажуулж, аймгийн ИТХ, ЗДТГ, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн цахим сайтад байршуулав.

БҮЛЭГ 1. ХАЛААЛТЫН ЗАРДЛЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨЖ, ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭГ ШИНЭЧЛЭХ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭН АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Төсөвт байгууллагуудын халаалтын зардлыг барилгын хувийн хэрэг, бодит талбайн хэмжээнд үндэслэн төлөвлөөгүй байна.

1.1.1 Орон нутгийн төсөвт байгууллагуудын халаалтын зардлыг 2021 онд 7,761.3 сая төгрөгөөр төлөвлөснийг Сангийн яамнаас 5,331.5 сая төгрөгөөр, 2022 онд 9,477.6 сая төгрөгөөр төлөвлөснийг Сангийн яамнаас 8,459.5 сая төгрөг, 2023 онд 10,769.6 сая төгрөгөөр төлөвлөснийг Сангийн яамнаас 10,885.6 сая төгрөгөөр тус тус хянаж, 2021 онд 2,429.8 сая, 2022 онд 1,018.1 сая төгрөгөөр дутуу, 2023 онд 116.0 сая төгрөгөөр нэмж баталсан байна. График 1.



2021, 2022 онуудад халаалтын зардлыг дутуу төлөвлөсөн шалтгаан нь Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 7.3-д орон нутгийн дулааны үнэ тарифыг нэмэгдүүлэхгүй байх, төвлөрсөн халаалтад холбох, сумдын уурын зуухыг төвлөрсөн халаалтай болгосноор төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх, сумдын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын түлш, халаалтын зардлыг өр, авлага үүсгэхгүйгээр батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэх гэсэн заалтыг баримтлан хасаж баталсантай холбоотой байна.

1.1.2 Ховд аймгийн хэмжээнд 13 сум төр хувийн хэвшлийн түншийн гэрээгээр хувийн аж ахуй нэгжээс, 2 сум ОНӨААТҮГ-аас, аймгийн төвийн төсвийн байгууллагууд Ховд дулааны станц ТӨҮГ, Бадамлах дөл ХХК -уудаас халаалтын гэрээ байгуулан ажиллаж байна. Халаалтын зардлын төсвийн төслийг боловсруулахдаа аймгийн ГХБХБГ-аас барилгын талбайд хийсэн хэмжилт, дулаан эрчим хүчээр хангах гэрээнд тусгасан барилгын хэмжээний дагуу тооцоолон төлөвлөж, Буянт, Мөст сумууд халаалтын нэгдсэн системд холбогдоогүй тул өмнөх оны түлшний зарцуулалтын гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.

1.1.3 Аудитын явцад түлш халаалтын зардлын төлөвлөлтийг орон нутгийн байгууллага бүрээр дулаанаар хангагч компаниудтай байгуулсан гэрээтэй түүвэрлэн тулгахад 2022 онд нэгдсэн халаалтад холбогдсон 10 байгууллагын төсвийг 169.7 сая төгрөгөөр илүү, 31 байгууллагын төсвийг 512.0 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6.1¹, 6.4.1² -д заасан заалтыг зөрчсөн байна. (Хавсралт 1) Томоохон үнийн дүн бүхий байгууллагуудын илүү дутууг дурдвал:

- Эрдэнэбүрэн сумын ЗДТГ 23.5 сая, Ховд сумын ЕБС 97.6 сая, цэцэрлэг 11.4 сая, соёлын төв 52.9, Эрүүл мэндийн төв 17.6 сая, Манхан сумын ЗДТГ 11.5 сая, Мөнххайрхан сумын сургууль 68.7, соёлын төв 30.9, Үенч сумын соёлын төв 47.9, Дарви сумын Эрүүл мэндийн төв 17.6 сая төгрөгөөр тус тус дутуу,
- Мянгад сумын Сургууль 33.7 сая, ЗДТГ 5.2 сая, Эрдэнэбүрэн сумын соёлын төв 12.0 сая, Цэцэг сумын Соёлын төв 12.0 сая, цэцэрлэгийг 4.3 сая төгрөгөөр тус тус илүү,

¹ “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”

² 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчмыг хэрэгжүүлэх”

Мөн Эрдэнэбүрэн сумын музейн барилга, Дуут сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөл, Зэрэг сумын эрүүл мэндийн төвийн хуучин барилга зэрэг байруудыг ашиглаагүй байхад халаахаар төлөвлөсөн нь төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөөгүй байна.

Зарим сургуулиудын дотуур байрны халаалтын зардлыг айл өрхийн тарифаар мөрдөөгүйгээс 397.5 сая төгрөгийг илүү санхүүжүүлсэн байна.

1.1.4 Эрчим хүчний салбарт мөрдөгдөж буй аж ахуйн харилцааны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3.1⁵, 5.3.4⁶-д заасны дагуу сургуулиудын дотуур байрыг талбайн хэмжээгээр, айл өрхийн тарифаар тооцон төлөвлөөгүйгээс халаалтын зардлыг 2021, 2022 онуудад 397.5 сая төгрөгөөр хэмнэх боломжийг алдаж, илүү санхүүжүүлжээ.

Хүснэгт 1. Сумдын сургуулийн дотуур байрны илүү төлсөн халаалтын зардал

д/д	Сумын нэр	Дулаанаар хангагч байгууллагын нэр	ЭХЗЗ-ийн тариф		Талбай		Эзлэхүүн		Зөрүү
			м2	м3	м2	Төлбөр	м3	Төлбөр	
1	Ховд сум	Бүрэн стандарт	0.9	1.45	1,614.0	11,620.8	4,842.0	56,167.2	(44,546.4)
2	Эрдэнэ-бүрэн		0.9	1.45	2,141.6	15,419.5	6,424.8	74,527.7	(59,108.2)
3	Дуут	Эрдэс тайга	0.9	1.45	750.0	5,400.0	2,230.0	25,868.0	(20,468.0)
4	Чандмань		0.87	1.4	1,127.0	7,843.9	3,381.0	37,867.2	(30,023.3)
6	Үенч	Мирай кэнсэнцү	0.9	1.45	2,158.0	15,537.6	6,474.0	75,098.4	(59,560.8)
7	Мянгад	Тоосгон Уул	0.9	1.45	750.0	5,400.0	2,480.0	28,768.0	(23,368.0)
8	Дөргөн	Жигүүрт Ажнай	0.9	1.45	606.3	4,365.4	1,818.9	21,099.2	(16,733.9)
9	Алтай	Тоосгон Уул	0.9	1.45	1,328.0	9,561.6	3,388.0	39,300.8	(29,739.2)
10	Мөнххайр-хан	Солонго талст	0.9	1.45	744.4	5,359.7	2,233.1	25,904.0	(20,544.3)
12	Зэрэг	Тээлийн Илч ОНӨААТҮГ	0.4	1.227	969.6	3,102.7	2,715.0	26,650.4	(23,547.7)
13	Дарви	Цахиур илч	0.84	1.35	1,173.5	7,885.9	3,286.0	35,488.8	(27,602.9)
14	Цэцэг	Эрчим дөл	0.84	1.35	958.4	6,440.4	1,951.2	21,073.0	(14,632.5)
15	Манхан		0.84	1.35	1,173.9	7,888.6	3,284.4	35,471.5	(27,582.9)
Дүн					15,494.7	105,826.2	44,508.4	503,284.2	(397,458.0)

Харин Бадамлах дөл ХХК, Булган түшиг ХХК-иуд нь сургуулийн дотуур байрын халаалтын төлбөрийг холбогдох хууль, журмын дагуу талбайн хэмжээгээр, айл өрхийн тарифаар тооцон гэрээ байгуулан авч байна.

3 Аливаа барилга байгууламж, орон сууц нь дулааны тоолуур суурилагаагүй бол дулааны эрчим хүчний төлбөр тооцоог энэхүү дүрэмд заасны дагуу эзлэхүүн болон талбайн хэмжигдэхүүнээр гэрээний дагуу тооцно. Орон сууцны барилгыг ахуйн зориулалтаар нь ашиглаж, хүн амьдарч байгаа бол талбайн хэмжигдэхүүнээр, үүнээс бусад нөхцөлд эзлэхүүнээр тооцно.
 6 Аж ахуйн үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдсан барилгад, дулааны тоолуур суурилуулах боломжгүй тохиолдолд халаалтын төлбөрийг эзлэхүүнээр тооцно. Тухайн барилгын халаалтын төлбөр тооцох эзлэхүүнийг өрөөний урт, өргөн, өндөр/давхрын бодит өндөр/-ийн хэмжээгээр тодорхойлно. Анхны батлагдсан зургаас өөр зориулалтаар уг барилгыг ашиглах бол мэрэгжлийн байгууллагын дүгнэлт, дулааны эрчим хүчээр найдвартай хангах техникийн хувьд боломжтой эсэх тооцоог үндэслэн эх үүсвэрийг тогтооно.

1.1.5 Жаргалант сумын хэмжээнд Ховд дулааны станц ТӨХК-наас 14 байгууллага, Бадамлах дөл ХХК-наас 11 байгууллага, нийт 25 байгууллагууд гэрээ байгуулан дулаанаар хангагдаж байна.

Аудитаар зарим байгууллагуудын дулаан нийлүүлэх гэрээг барилга байгууламжийн хувийн хэрэг, зураг төсвүүдтэй тулгахад Хөгжил политехник коллежийн шинээр баригдсан хичээлийн байрыг 1,698.4 м3, Жаргалант сумын 7-р цэцэрлэгийн 2-р байрыг 1,945.5 м3, 11 дүгээр цэцэрлэгийн барилгыг 438.8 м3, 4 дүгээр цэцэрлэгийн барилгыг 219.85 м3-аар тус тус илүү гэрээнд тусгаж 57.0 сая төгрөгийн дулааны төлбөрийг илүү төлсөн нь аж ахуйн харилцааны дүрмийн 5.1.1-д заасан заалт, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна. Харин Жаргалант сумын 9-р цэцэрлэг 1,333.8 м3, 5 дугаар цэцэрлэг 718 м3, 6 дугаар цэцэрлэг 322.5 м3, 12 дугаар цэцэрлэг 1,190м3-аар тус тус барилгын хувийн хэрэгт байгаа дүнгээс дутуу тооцсон байна.

Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2018 оны 292 тоот тогтоолын дагуу төсөвт байгууллагуудын халаах талбайг бодитой хэмжсэнээр халаалтын зардлыг 298.4 сая төгрөгөөр хэмнэх боломж байна.

1.1.6 Төвлөрсөн халаалтад холбогдсон Булган, Ховд, Чандмань, Дөргөн, Алтай, Мөнххайрхан, Мянгад сумууд аймгийн ГХБХБГ-аар хэмжилтийг хийлгэсэн, Эрдэнэбүрэн, Зэрэг, Цэцэг, Дарви, Манхан сумууд дулаанаар хангагч компанитай хамтран хэмжилт хийсэн зарим байгууллагуудын талбайн хэмжээ зөрүүтэй байна. Тухайлбал:

- Мөнххайрхан сумын хүүхдийн цэцэрлэг, ЗДТГ-ын барилгын хэмжилтийг хийхдээ тооцооллын алдаа гаргасан, соёлын төв гэрээг байгуулахдаа хэмжилтийн дүнгээс 3,669.5 м3-аар илүү хийсэн,
- Алтай, Дөргөн сумын төсөвт байгууллагууд төсвийн төлөвлөлтөд хийсэн хэмжилтийн дагуу эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс баталсан тарифтай уялдуулан төлөвлөөгүй,
- Эрдэнэбүрэн сумын соёлын төв музейн барилгыг гэрээнд давхардуулан тусгасан,

1.1.7.ЭХЗХ-ны 2018 оны 292 дугаар тогтоолоор аж ахуйн харилцааны дүрэм”-ийг шинэчлэн баталсан ба тус дүрмийн 5.3.1-т “Аливаа барилга байгууламж, орон сууц нь дулааны тоолуур суурилагдаагүй бол дулааны эрчим хүчний төлбөр тооцоог энэхүү дүрэмд заасны дагуу эзлэхүүн болон талбайн хэмжигдэхүүнээр гэрээний дагуу тооцно”, 5.3.4-т “Аж ахуйн үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдсан барилгад, дулааны тоолуур суурилуулах боломжгүй тохиолдолд халаалтын төлбөрийг эзлэхүүнээр тооцно. Тухайн барилгын халаалтын төлбөр тооцох эзлэхүүнийг өрөөний урт, өргөн, өндөр/давхарын бодит өндөр/-ийн хэмжээгээр тодорхойлно” гэж заасан. Гэтэл халаалтын талбайг тооцох аргачлал шинэчлэгдэн батлагдсанаас хойш дулаанаар хангагч тусгай зөвшөөрөл бүхий байгууллагууд нь нийт төсөвт байгууллагуудын халаалтын талбайн хэмжилтийг журмын дагуу дахин шинэчилж хэмжилт хийгдээгүй байна.

ГХБХБГ болон дулаанаар хангагч аж ахуйн нэгжүүд нь хэмжилтийг хийхдээ хүчингүй болсон ЭХЗХ-ны 2014 оны 189 тоот журмыг баримталсан байна.

1.1.8 Аудитын хугацаанд 12 суманд томилолтоор ажиллан байгууллагуудын барилгын эзлэхүүнийг түүвэрлэн хэмжилт хийж, орон нутгийн төсөвт байгууллагууд болон дулаанаар хангагч аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээнд тусгасан халаах эзлэхүүний хэмжээтэй тулгахад Хавсралт 1-д тусгасан 36 байгууллагаас 12 байгууллагын 7,059.5 м3 талбайг дутуу, 25 байгууллагын 33,689.99 м3 талбайг илүү тооцсоныг батлагдсан тарифаар тооцоход 298.4 сая төгрөгийн төсвийн хэмнэлт бий болох боломж байна.

Иймд аймгийн Засаг даргын захирамжаар төсөвт байгууллагуудын халаалтын талбайд хэмжилт хийх ажлын хэсэг томилон нийт байгууллагуудын халаалтын талбайн хэмжилтийг үнэн зөв тогтоон, төлөвлөх шаардлагатай байна.

Дулаан эрчим хүчээр хангах, хэрэглэх тухай гэрээ болон төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээг шинэчлэн байгуулах шаардлагатай байна.

1.2.1 Монгол Улсын Их Хурлын 2009 оны 64 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 29 дүгээр тогтоол, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Эрчим хүчний сайдын 2014 оны 51 дүгээр тушаалыг үндэслэн 14 сумын нэгдсэн халаалтын үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Аймаг, сумын засаг даргатай байгуулсан төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээнд төслийн үргэлжлэх хугацаа заагаагүй байгуулсан 2 гэрээ, 10 жилээр 1 гэрээ, 15 жилээр 10 гэрээг байгуулсан бөгөөд гэрээнд заасан хугацаа дуусахад төрд шилжүүлэх нөхцөлийг тусгасан 9 гэрээ, тодорхой заалтгүй 4 гэрээ хийгджээ.

1.2.2 Вива зоне ХХК – ний Эрдэнэбүрэн, Ховд сумтай байгуулсан төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээний 1.2-д “Гэрээний нийт дүн нь ... улсын экспертизээр баталгаажуулж, батлагдсан зураг төсвийн үнэ байна.” гэж заасан ч зураг төсвийг магадлалаар баталгаажуулалгүйгээр гэрээ байгуулсан, концессын зүйлийг төрд шилжүүлэх асуудлыг тусгаагүй нь Концессын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2⁷, 21 дүгээр зүйлийн 21.1.23⁸ дахь заалтыг баримтлаагүй байна.

1.2.3 Төсвийн шууд захирагч нар дулаанаар хангагч компаниудтай гэрээг байгуулахдаа Эрчим хүчний тухай хууль, Иргэний хууль, Аж ахуйн харилцааны дүрэм, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм, Дулааны эрчим хүчний төлбөр тооцооны тухай журмыг тус тус мөрдсөн байна. Гэрээнд халаах талбайн хэмжээг барилга, байгууламж тус бүрээр нь тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2¹²-д заалттай нийцээгүй, дулааны чанарын үзүүлэлт, шугам сүлжээний эзэмшлийн зааг тогтоогоогүй, хэрэглэгчийн зарим эрхийг хязгаарласан, дулааны тасалдлаас учирсан аливаа хохирлыг нөхөн төлөх асуудал, эрчим хүчний тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь заалтыг тусгаагүй зөрчил нийтлэг байна.

1.2.5 Хангагч, хэрэглэгч нь дулаанаар хангах гэрээг жил бүрийн халаалтын улирал эхлэх хугацаанд буюу эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон хугацаанд байгуулаагүй нь ЭХЗХ-ны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 2.6-г зөрчсөн байна. Үүнд: Мөнххайрхан сумын ЗДТГ, Соёлын төв, Зэрэг сумын ЗДТГ, Цэцэг, Дарви, Манхан сумдын Соёлын төвүүд халаалтын хугацааг 8 сараар, Булган, Алтай, Мянгад сумын байгууллагууд гэрээг төсвийн жилээр, аймгийн ЗДТГ, Жаргалант сумын 4, 16-р цэцэрлэгүүд 2023 оны гэрээг байгуулаагүй байна.

1.2.6 Ховд дулааны станц ТӨХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифт ЭХЗХ-ны 2023 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023 оны 03 сарын 23-ны өдөр бүртгэснээр хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээр 14 төсвийн байгууллагууд халаалтын зардлын төсөвт 2023 онд тодотгол хийгдээгүйгээс 264.4 сая төгрөгийн өр үүссэн тул 2023 оны дулаан эрчим хүчээр хангах гэрээг байгуулаагүй байна.

Хамтын ажиллагааны гэрээнд хөрөнгө оруулалтын өртөг нөхөх хугацааг бодитой тооцоогүй, техник эдийн засгийн үндэслэлд магадлал хийгдээгүй байхад гэрээ байгуулан орон нутгийн өмчийг үнэ төлбөргүй ашиглуулсан, аймаг, сумдын засаг дарга нар байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг одоог хүртэл дүгнээгүй байна.

⁷ Концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол концессын гэрээгээр шинэчлэн сайжруулах концессын зүйл нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид хамаарна.

⁸ концессын гэрээний хугацаа, түүнийг сунгах, гэрээний эрх, үүргийг шилжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, концессын гэрээ ба холбогдох бусад гэрээний хоорондын харилцаа, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, үүргээ биелүүлээгүй тохиолдол ба гэрээ цуцлах, дуусгавар болох үндэслэл, концессын зүйлийг хүлээлгэн өгөх ба шилжүүлэх арга хэмжээ, маргаан шийдвэрлэх журам

¹² 5.1.2.төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;

олон олон асуудлууд тулгарсаар байхад хамтын ажиллагааны гэрээг дүгнээгүй байна. Мөн гэрээнд шинэ хэрэглэгчдийг дулаан хангамжийн төсөлд хамруулж болохоор тусгасан боловч сумдын төвлөрсөн дулаанд шинээр холбосон хэрэглэгч /айл өрх, аж ахуйн нэгж/-ийн тоо харилцан адилгүй байгаа бөгөөд гэрээнд шинэ хэрэглэгчийн тоог нарийвчлан тусгаагүйгээс гэрээний хэрэгжилтийг үнэлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Сумдад үйл ажиллагаа явуулж байгаа нэгдсэн дулаанаар хангагч аж ахуйн нэгжүүдийн удирдлагууд сумандаа ажиллахгүй, ажил хариуцуулан 1 хүн томилж, орон нутгаас 8-12 тооны галч гэрээлэн ажиллуулж байгаа ч галч нарын нийгмийн хамгааллын асуудал, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагын биелэлт хангалтгүй байна.



Дарви сум. Цахиур Илч ХХК .хашаагүй , халаалтын нөөц тогоо



Дөргөн сум.Жигүүр Ажнай ЗДТГ-т бүртгэлтэй уурын зуухыг ашигласан байдал

Аудитын явцад дулаанаар хангагч байгууллагууд дээр ажиллахад дараах нийтлэг зөрчлүүд илэрлээ.

- Дарви суманд үйл ажиллагаа явуулж байгаа Цахиур илч ХХК нь хашаа татаагүйгээс эргэн тойронд нүүрсний хог үүссэн, уурын зуухны яндангийн өндөр бага тул их хэмжээний тортог бууж байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсэн, аваарын нөөц зуухыг суурилуулаагүй, халаалтын горим алдагдаж 56 градусаас дээш халах боломжгүй,
- Чандмань суманд үйл ажиллагаа явуулж байгаа Эрдэс тайга ХХК нь сумын ИТХ-аас нүүрсний тоосжилтыг бууруулах арга хэмжээ авахыг үүрэг болгосон ч хэрэгжүүлээгүй, хуучин уурын зуухны барилгыг түрээслэх гэрээ хийсэн ч төлбөрийг төлдөөгүй
- Зэрэг сумын Тээлийн элч ОНӨААТҮГ-ийн эргэн тойронд хөө тортог үүссэн, хогоо зайлуулаагүй,
- Бүх дулаан хангагч аж ахуйн нэгжүүд усны дүгнэлт гаргуулаагүй, усны төлбөр төлөхгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашигладаг,
- Орон нутгаас 8-12 хүнийг ажлын байраар хангаж байгаа ч хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм мөрдөөгүй, амрах байр, ажлын орчин муу, нүүрсний хөөн дунд амардаг, усанд орох тусгай өрөөгүй, барилгын дотор хананууд, гадна орчин, халаалтын тогоонууд утаа тортог, тоосонд дарагдсан орчинд ажилладаг,
- Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлдэггүй,
- Зарим дулаанаар хангагч компаниуд халаалтын тогооны ашиглалтын бүртгэл, үйлдвэрлэж байгаа дулааны градусын бүртгэл, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл олгосон жагсаалт зэргийг хөтлөөгүй, хэмжих хэрэгслийг баталгаажуулаагүй, үнс асгах талбайгүй зэрэг зөрчлүүд түгээмэл байна.

1.2.11 Буянт суманд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээгээр нэгдсэн шугам сүлжээний ажлыг гүйцэтгэж буй Жаргалант Буд Трейд ХХК нь захиалагч талаас газрын асуудлыг шийдвэрлээгүйгээс гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгээгүй байна.

1.2.12 Ховд дулааны станц ТӨХК нь химийн лабораторийг ажиллуулан усны хатуулаг, төмрийн шинжилгээг хийж, сард 1-2 удаа PH, төмөр, кальцийн хатуулаг, нүүрс хүчлийн хий, ерөнхий шүлтлэгийг тооцоолон, шинжилгээний хариуг баталгаажуулан ерөнхий инженерээр батлуулан, Эрчим хүчний үндэсний төвийн итгэмжлэгдсэн лабораториор 2021, 2022 онуудад 1 удаа хийлгэсэн, 2023 онд шинжилгээг хүргүүлсэн хариу ирээгүй байна.

Бадамлах дөл ХХК нь химийн лабораторийг ажиллуулан усны ерөнхий хатуулгийг хэмжин баталгаажуулдаг, химийн инженер нь сард 1-2 удаа PH, кальцийн хатуулаг, нүүрс хүчлийн хий, ерөнхий шүлтлэгийг хэмжин хянаж байгаа ч, итгэмжлэгдсэн лабораториор хянуулаагүй, сумуудад үйл ажиллагаа явуулж байгаа дулаанаар хангагч аж ахуйн нэгжүүд усны чанарт шинжилгээ хийлгэж баталгаажуулаагүй байна.

1.2.13 Аудитын явцад халаалтын чанарын үр нөлөөг тодорхойлох зорилгоор төсөвт байгууллагуудын албан хаагчид, сургуулийн дотуур байранд амьдардаг онлайнаар 1618, асуулгын хуудсаар 419, нийт 2037 санал асуулга авч үр дүнг нэгтгэлээ.

Халаалтын чанарт үнэлгээ өгөх асуултад 33% буюу 668 хүн халаалт сайн, 46% буюу 932 хүн дунд зэрэг, 18% буюу 365 хүн халаалт муу, 3% буюу 72 хүн халаалт хааяа доголддог гэж хариулсан байна. График 3. Халаалтын чанарын судалгаа



Судалгааны дүнгээс үзэхэд албан хаагчдын халаалтын чанарт өгөх сэтгэл ханамж хангалтгүй байгааг харуулж байна.



График 6-д сумдын халаалт нийлүүлэгч компаниудын халаалтын чанарт өгсөн иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг үзүүлээ. Эндээс үзэхэд төр, хувийн хэвшлийн түншийн гэрээний дагуу хөдөөгийн 14 сумын төсөвт байгууллагууд дулаан орчинд ажиллах нөхцөл зохих түвшинд бүрдэн ажиллаж байгаа ч халаалтын чанар харилцан адилгүй байна.

БҮЛЭГ 2. ХАЛААЛТЫН ЗАРДАЛД ДОТООД ХЯНАЛТЫГ ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР 826.0 САЯ ТӨГРӨГИЙН ТӨСВИЙН ХЭМНЭЛТ ХИЙХ БОЛОМЖТОЙ БАЙНА.

Төсөвт байгууллагуудын дулааны алдагдлыг бууруулах талаар тодорхой ажлуудыг хэрэгжүүлэн ажилласан ч зарим барилгууд дулааны алдагдалтай байна.

2.1.1. Аймгийн засаг даргын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах бүрэлдэхүүнд ЭХЗЗ-ийн зохицуулагч, холбогдох мэргэжилтэн нар сумуудад ажиллан заавар зөвлөгөөг өгч, хяналт хэрэгжүүлэн, байгууллагуудын удирдлагууд дулааны алдагдлыг бууруулах, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах талаар тодорхой ажлуудыг хэрэгжүүлж байна.

2021 онд ОНХО-ын төлөвлөгөөнд Ховд дулааны станцын аваарын нөөц бүрдүүлэлтэд 77.3 сая төгрөг, ЕБ-ын сургууль, цэцэрлэгийн өвөлжилтийн бэлтгэл ажил хангах арга хэмжээний хүрээнд нэн шаардлагатай урсгал засварын зардалд 50.0 сая, аймгийн ЗДТГ-ын шугам сүлжээ, сантехникийн засвар 44.9 сая төгрөг, нийт 172.2 сая төгрөгөөр тус тус баталж хэрэгжүүлсэн байна.

2022 онд аймгийн ОНХО-ын төлөвлөгөөнд аймгийн ЕБС, цэцэрлэгийн өвөлжилтийн бэлтгэл хангах, болзошгүй эрсдэлийн зардал 100.0 сая төгрөгийг аймгийн ИТХ-аас баталж гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн байгууллагын дулааны шугам засвар шинэчлэлтийн 7 ажилд 64.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн ОНХО-ын төлөвлөгөөнд Ховд дулааны станцын аваарын нөөц бүрдүүлэлтэд 168.4 сая төгрөг, Дөлгөөн төвийн дулаан дамжуулах төв байгуулах 102.1 төгрөг, 3-р цэцэрлэгийн барилгын дээврийн засвар 35.0 сая, цэцэрлэгийн барилгын дээвэр засвар /Мөст сум/ 20.0 тус тус баталж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажлыг хүлээн авсан байна.

Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд шугам сүлжээний засвар, шинэчлэлтийн ажилд хөрөнгө гаргах тухай аймгийн Засаг даргын 2022 оны А/575 захирамжаар Ховд хотын нийтийн орон сууц, сургууль цэцэрлэгийн цэвэр бохир, дулааны шугам сүлжээний засвар шинэчлэлтийн ажилд зориулан 66.8 сая төгрөгийг зарцуулахаар хуваарилж Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэгийн дотор дулааны шугам сүлжээний засварт 15.0 сая, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын байрны гадна дулааны шугам сүлжээний засварт 11.0 сая, Жаргалант сумын 2 дугаар сургуулийн дулааны шугам сүлжээний засвар 2.5 сая, Буянт сумын ЕБС-ийн дулааны шугам сүлжээний засвар 7.0 сая, Буянт сумын цэцэрлэгийн дулааны шугам сүлжээний засварт 4.0 сая, Жаргалант сумын 3 дугаар сургуулийн дулааны шугам сүлжээний засварыг 4.0 сая төгрөгөөр тус тус гүйцэтгүүлсэн байна.

2.1.2 Халаалтын чанар хангалтгүй байгаа шалтгааныг хэрхэн дүгнэж байгаа талаарх асуумжийг сайн гэж хариулснаас бусад хүмүүсээс авахад 48% нь халаалт муу ирдэг, 11% хана дулаан алдалттай, 20% цонх дулааны алдагдал ихтэй, 21% нь бусад шалтгаантай гэж хариулсан байна. График 7.

Судалгаанд оролцогчид сумдын дулаанаар хангагч байгууллагууд халаалтыг шаардлагын хэмжээнд өгдөггүй, шөнийн цагаар галлагааг зогсоодог үүнээс хамаарч зарим байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах, хүүхдийн сурч боловсрох таатай орчин бүрдэхгүй байх, ажиллаж сурч байгаа орчныхоо хүйтрэлтэй холбоотой хүн амын өвчлөл, ханиад томуу нэмэгддэг гэж хариулжээ.



2.1.3 Аудитаар түүвэрлэн хянахад Жаргалант сумын 2, 12 дугаар цэцэрлэг, музей, номын сан, Зэрэг сумын ЕБС-ийн хичээлийн байр, Цэцэг сумын соёлын төв, Ховд сумын цэцэрлэг, эрүүл мэндийн төв, Дарви сумын цэцэрлэг, соёлын төв, Дөргөн сумын ЕБС хичээлийн байр

зэрэг байгууллагуудын байрны барилгуудын дээвэр, цонх дулаан алдалттай, халаалт шаардлагын түвшинд хүрч халдаггүй дулааны алдагдал их байна.

Засгийн газрын 144 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын 2019 оны 85 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаж төсвийн байгууллагуудыг тоолууржуулан төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2.1.4 Орон нутгийн төсөвт байгууллагуудын 2021 оны халаалтын зардлыг 5,331.5 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 4,920.8 төгрөг, 2022 оны халаалт 8,459.5 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 8,347.6 төгрөг, 2021 онд 410.7 сая, 2022 онд 111.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Төсөвт байгууллагуудын халаалтын төлбөртэй холбоотой хэрэг маргаан шүүхээр шийдвэрлэгдэж, шүүхийн шийдвэрээр 2022 онд 1,283.0 сая төгрөг, 2023 онд 546.0 сая, нийт 1,829.0 сая төгрөгийг аймгийн төсвөөс нэхэмжлэгч байгууллагад олгожээ. Гэтэл төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээнд батлагдсан төсвөөр зардлыг санхүүжүүлэхээр тусгасан байтал Иргэний хэргийн анхан шатны шүүхэд тайлбар нотлох баримтыг төрийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнууд хангалттай бүрдүүлэн өгөөгүйгээс шүүх нэхэмжлэгчийн талд шийдвэрлэжээ.

2.1.5 Халаалтын зардлаас төсөвт байгууллагууд 2021 онд 48.8, 2022 онд 37.0 сая төгрөгийг тус тус урсгал засвар, шатахуун, бусад зардалд зарцуулсан байна. Тухайлбал: Мөст сумын сургууль хүнсний материалын үнэ, Манхан сумын ЗДТГ интернэт кабелийн үнэ, Дөргөн сумын ЗДТГ нэвтрүүлгийн төлбөр, Булган сумын 2 дугаар сургууль цемент блокийн үнэ, камерын үнэ гэх мэт зардлуудад, 2022 онд асрамжийн газар ажлын хөлс, Мянгад сумын ЗДТГ, Мөст сумын соёлын төв ажилчдад түлээ нүүрсний хөнгөлөлт, Дөргөн соёлын төв, Мөнххайрхан сумын сургууль, Мөст сумын ЗДТГ, сургууль, ЭМТ, Алтай сумын ЗДТГ, Үенч сумын ЗДТГ, Чандмань сумын ЭМТ, цэцэрлэг зэрэг байгууллагууд гэрэл цахилгааны төлбөр, аймгийн ЗДТГ бланкны үнэ, буцалтгүй тусламж зэрэг зардлуудад гүйлгэн зарцуулжээ.

График 8 ориулалт бус зарцуулалт сая.төг



Энэ нь нягтлан бодогч, төрийн сангийн мэргэжилтнүүдийн дотоод хяналт сулаас Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5¹⁷ дахь заалт, Сангийн сайдын 190 тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн байна

2.1.6 Ховд, Эрдэнэбүрэн, Дуут, Мянгад, Зэрэг, Дарви сумын Эрүүл мэндийн төвүүд эмийн сангийн үйл ажиллагаа эрхэлж буй хувийн аж ахуй нэгжүүдийн халаалтын зардалд 2.7 сая орчим төгрөг, Ховд, Эрдэнэбүрэн, Дөргөн, Алтай сумын ЗДТГ нь цагдаагийн хэсгийн байрны халаалтын зардалд 21.4 сая төгрөг зарцуулсан нь улсын төсвийн байгууллагын төсөвт хамаарах зардлыг санхүүжүүлсэн байна.

Харин зарим сумдын халаалт нийлүүлэгч аж ахуйн нэгжүүд нийгмийн хариуцлагын хүрээнд халуун ус, ахмадын өргөө, цагдаагийн хэсгийн байр гэх мэт олон нийтийн үйл ажиллагаанд ашигладаг байруудад үнэ төлбөргүй халаалт нийлүүлж байна.

2.1.7 Монгол улсын Засгийн газрын 2020 оны 144-р тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулаан эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулахыг үүрэг болгосон.

¹⁷ "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"

Аймгийн хэмжээнд 2021 онд Хөшөөт хөгжил сангаас төсөвт байгууллагад дулааны тоолуур нийлүүлэх ажлыг 39.5 сая төгрөгөөр гэрээ хийж Сайрын хороо ХХК шалгарч 12 байгууллагад тоолуур суурилуулах ажил гүйцэтгэж хүлээлгэн өгсөн байна.

Гэвч байгууллагууд дулааны тоолуур суурилуулснаас хойш тоолуурын заалтаар төлбөр тооцоогоо бодож төлөөгүй, Засгийн газрын 144 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын 2019 оны 85 дугаар тогтоолыг мөрдөөгүй, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулсан байна.

Жаргалант сумын 5,11,16 дугаар цэцэрлэгүүд, 2 дугаар сургууль зэрэг байгууллагууд эрчим хүчний төлбөрийг тоолуурын заалтаар төлөх саналыг дулаанаар хангагч компанид хүргүүлсэн ч хүлээн авч гэрээ хийгээгүй байна.



Суурилсан ч ажиллуулахгүй байгаа тоолуур

2.1.8 Аудитаар төсвийн байгууллагууд халаалтын үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлээгүй, дулаан эрчим хүчээр хангах гэрээнд халаалтын чанарын үзүүлэлтийг тусгаж, гэрээг дүгнээгүй зэргээс шалтгаалан халаалт аваагүй, дутуу нийлүүлсэн дулааны төлбөрийг бүрэн шилжүүлж, төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй зөрчлүүд илэрлээ.Үүнд:

- Жаргалант сумын 4 дүгээр цэцэрлэг 2023.03.10-ны өдрөөс 2023.05.15-ны өдрийн хооронд зүүн жигүүрийн халаалтыг авах боломжгүй нөхцөл үүсэж халаалтыг хангагч байгууллагад мэдэгдэн тасалсан, 2023.09.15-ны өдрөөс халаалтаа авах боломжгүйгээ хангагч талд мэдэгдэж 2023.10.05-ны өдрөөс халаалт авсан бөгөөд халаалтын төлбөрийг бүрэн төлсөн,
- Жаргалант сумын 2 дугаар сургууль 2023 оны 9-р сард төв шугамд гэмтэл гарч засвар хийгдэж халаалт 8 хоног аваагүй, халаалтын зардлыг бүрэн шилжүүлсэн,
- Жаргалант сумын 1 дүгээр сургууль 2023 оны 9-р сард төв шугамд засвар хийгдэж халаалтыг 10 сарын 01-нд авсан, 9 дүгээр сарын халаалтын зардлыг бүрэн шилжүүлсэн,
- Аймгийн Хөгжим драмын театр нь 2023 онд гадна шугамд гэмтэл гарч засвар хийгдэж, 2023.10.22-ны өдрөөс авсан бөгөөд 10 дугаар сарын халаалтын зардлын хасаж тооцоогүй бүрэн нэхэмжилсэн дүнгээр төлбөрийг бүрэн төлсөн байна

Аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл нь хууль, журмаар олгогдсон эрх үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, үнэ тогтоох аргачлалыг мөрдөж ажиллаагүй байна.

2.2.1 Ховд аймгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчит 3, хувийн 10, нийт 13 дулааны үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүд үйл ажиллагаа явуулан төсөвт байгууллагуудад дулаан хангах үйлчилгээг үзүүлж байна.

Аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл нь 2021-2023 онд дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 1 компанид шинээр, 10 компанийн тусгай зөвшөөрлийг сунгасан байна. Харин тусгай зөвшөөрлийн хугацаа сунгаагүй үйл ажиллагаа явуулж байгаа дараах компаниуд байна. Үүнд:

д/д	Сум, байгууллагын нэр	Зөвшөөрөл авсан огноо	Дууссан огноо
1	Дарви суманд Цахиур илч ХХК (Энержи импиар)	2019.03.06	2022.03.06
2	Дөргөн суманд Жигүүрт ажнай ХХК	2020.4.15	2023.4.15
3	Жаргалант суманд Бадамлах дөл ХХК	2015.07.19	2020.07.19
4	Мянган сутайн буян ОНӨААТҮГ	2020.07.16	2023.07.16

Ховд аймгийн нэгдсэн дулаанаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа 15 компанийн тусгай зөвшөөрөл авахаар ирүүлсэн материалыг холбогдох шаардлагын дагуу хянахад нөхцөл шаардлагыг бүрэн бүрдүүлээгүй 13 компанид тусгай зөвшөөрөл олгосон нь

Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2¹⁹, 21.5²⁰, ЭХЗХ-ны 2019 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 3.1 дэх заалтыг зөрчжээ. Үүнд:

- Булган түшиг ХХК, Мянган сумтайн ОНӨААТҮГ техник эдийн засгийн үндэслэл ирүүлээгүй,
- Мянган сумтайн буян ОНӨААТҮГ нь үйлдвэрлэх, түгээх, борлуулах, эрчим хүчний төрөл, хэмжээ, чанарын үзүүлэлт, санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавч, мэргэжлийн боловсон хүчин, дадлага туршлагын талаарх мэдээлэл ирүүлээгүй,
- Жигүүрт ажнай ХХК, Мянган сумтайн ОНӨААТҮГ-ууд үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл хангамж, хэрэглээний тэнцэл ирүүлээгүй,
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ ирүүлээгүй 4 компани. үнэлгээ
- Булган түшиг ХХК, Мянган сумтайн ОНӨААТҮГ, Тээлийн илч ОНӨААТҮГ, Бадамлах дөл ХХК -нууд. Тоосгон уул ХХК, Булган түшиг ХХК, Жигүүрт ажнай ХХК, Мянган сумтайн ОНӨААТҮГ, Тээлийн илч ОНӨААТҮГ, Бадамлах дөл ХХК, Эрчим дөл ХХК, Солонго талст ХХК, Вива зон ХХК -нууд байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг ирүүлээгүй,
- Цахиур илч ХХК-ний зөвшөөрөл хүссэн материал нь зохицуулах зөвлөлөөс ирүүлээгүй байна.

2.2.2 Дарви суманд дулаан халаалтын үйл ажиллагааг эрхэлж байсан Энержи импиар ХХК нь дулаан үйлдвэрлэх, түгээх, борлуулах тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг бусдад шилжүүлсэн нь Эрчим хүчний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, Төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ зэргийг зөрчсөн байна.

Мөн Булган суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн дулааны үйлдвэрийг гэрээний үндсэн дээр ашиглан дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагааг Булган түшиг ХХК нь 2022 оны 10 дугаар сараас тусгай зөвшөөрөл олгогдоогүй байхад дулаан түгээх үйл ажиллагааг эрхлэн явуулсан нь Эрчим хүчний тухай хуулийн 12.1²¹ болон 22.4²² дэх заалтуудыг зөрчсөн байна.

2.2.3 Ховд аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөл нь 2023 оны 6 дугаар сард дулаанаар хангагч байгууллагын үнэ тарифыг шинэчлэн тогтоосон байна. Дулааны үнэ тарифыг тогтооход холбогдох зарчим аргачлалыг баримтлаагүй, байгууллагуудаас ирсэн үнийн саналыг үндэслэлгүйгээр ижилхэн 30 хувиар нэмсэн байна.

Хавсралт 3-д дурдсан үнэ шинэчлэн тогтоосон байдлыг хүснэгтээс үзэхэд Алтай, Дуут, Мянгад, Мөнххайрхан, Үенч, Ховд, Дөргөн, Эрдэнэбүрэн сумдын үнэ ижил 1885 төг/м³, Дарви, Манхан, Цэцэг сумд үнэ ижил 1755 төг/м³ тогтоосон байгаа нь Эрчим хүчний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 -д Тариф тогтоохдоо дараах зарчмыг баримтална, Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 231 тоот тогтоолоор “Цахилгаан дулааны эрчим хүчний үнэ тариф тогтоох аргачлал”-ыг баримтлан ажиллахгүй байна. Мөн үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурласан байх, цахилгаан, дулааны хангалтад хэрэглэгчдээс тавих шаардлагатай уялдуулан хэрэглэгчийн ангилал тус бүрээр өртөг, зардлыг хуваарилах гэх мэт нөхцөл байдлыг харгалзан үзсэн эсэх нь тодорхойгүй байна.

Аймгийн ЭХЗХ нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 231 дүгээр тогтоолоор баталсан “Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тариф тогтоох аргачлал”-ыг бүрэн мөрдөөгүй, дулаанаар хангагч компаниудын нүүрс тээвэрлэх зай, төсөвт байгууллага, айл өрхийн тоо, халаах талбайн хэмжээ, халаалтын тогооны тоо зэргийг харьцуулан судлалгүйгээр үнэ тарифыг бодитой бус тогтоожээ. Тухайлбал: Нүүрсний татан авалтыг Хөшөөтийн уурхайгаас хийдэг хамгийн ойр 30 км зайтай Цэцэг сум, 130 км зайтай Манхан сумын үнэ тарифыг 1755 төгрөгөөр ажил тогтоосон байна. Мөн Зэрэг сумын

¹⁹ 21.2.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн ...14.26, 14.27, 14.28... дэх хэсэгт заасан тусгай зөвшөөрөл авахад эрхлэх үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана

²⁰ 21.5.Энэ хуулийн 21.4-т заасан хугацаанд баримт бичгийг нөхөн бүрдүүлж ирүүлээгүй бол өргөдөл гаргаагүйд тооцно

²¹ 12.1.Хуулийн этгээд дараахь үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ

²² 22.4.Тусгай зөвшөөрөл нь түүнийг олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно

сая, хэмжилтийг бодитой хийснээр 298.4 сая, нийтдээ 826.0 сая төгрөгийн төсвийн хэмнэлт бий болгох боломжтой байна.

Аудитаар 4 байгууллагын 2023 оны халаалт аваагүй, барилгын эзлэхүүнийг зөрүүтэй хийсэн 48.8 сая төгрөгийн алдааг тооцоо нийлүүлэн залрууллаа.

Залруулагдаагүй нийт 754.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 46.6 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоон, 419.99 сая төгрөгийн зөрчил арилгуулах 5 албан шаардлага өгч, 287.4 сая төгрөгийн 8 зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, хийсэн дүн шинжилгээ аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Төсөвт байгууллагуудын халаалтын зардлыг барилгын хувийн хэрэг, бодит талбайн хэмжээнд үндэслэн төлөвлөөгүйгээс гэрээний маргаан үүсэх эрсдэлтэй байна.
2. Зарим сургуулиудын дотуур байрны халаалтын зардлыг айл өрхийн тарифаар мөрдөөгүйгээс 397.5 сая төгрөгийг илүү санхүүжүүлсэн байна.
3. Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2018 оны 292 тоот тогтоолын дагуу төсөвт байгууллагуудын халаах талбайг бодитой хэмжсэнээр халаалтын зардлыг 298.4 сая төгрөгөөр хэмнэх боломж байна.
4. Дулаан эрчим хүчээр хангах, хэрэглэх тухай гэрээ болон төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээг шинэчлэн байгуулснаар талуудын эрх, үүргийг тодорхой болгон, дулаан халаалттай холбоотой дотоод хяналт сайжрахаар байна.
5. Хамтын ажиллагааны гэрээнд хөрөнгө оруулалтын өртөг нөхөх хугацааг бодитой тооцоогүй, техник эдийн засгийн үндэслэлд магадлал хийгдээгүй байхад гэрээ байгуулан орон нутгийн өмчийг үнэ төлбөргүй ашиглуулсан, аймаг, сумдын засаг дарга нар байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг одоог хүртэл дүгнээгүй байна.
6. Төсөвт байгууллагуудын дулааны алдагдлыг бууруулах талаар тодорхой ажлуудыг хэрэгжүүлэн ажилласан ч зарим барилгууд дулааны алдагдалтай байна.
7. Засгийн газрын 144 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын 2019 оны 85 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаж төсвийн байгууллагуудыг тоолууржуулан төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
8. Аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл нь хууль, журмаар олгогдсон эрх үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, үнэ тогтоох аргачлалыг мөрдөөгүй нь Эрчим хүчний тухай хуульд заасан холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
9. Төсвийн байгууллагууд дулаан нийлүүлэх гэрээний хэрэгжилтэд дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ :

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

НЭГ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Э.БОЛОРМАА ТАНАА:

1. Нэгдсэн дулаанаар хангагч компаниудтай байгуулсан төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээнд холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгах, зураг төсөвт магадлал хийлгээгүй болон гэрээ байгуулаагүй компаниудтай гэрээг шинэчлэн байгуулж, гэрээний дүн, хугацаа, сумдын төвлөрсөн дулаанд шинээр холбох хэрэглэгчийн тоог нарийвчлан тусгах,

2. Төсөвт байгууллагуудын халаалтын талбайн хэмжилтийг ЭХЗХ-ны 2018 оны 292 тоот тогтоолын дагуу шинэчлэн тогтоож, халаалтын зардлын төсвийг бодитой төлөвлөх
3. Төсөвт байгууллагуудын халаалтын гэрээний хэрэгжилтэд дотоод хяналт хэрэгжүүлэн, биелэлтийг дүгнэн ажиллах талаар төсвийн шууд захирагч нарт арга зүйн зөвлөмж хүргүүлэх
4. Засгийн газрын 144 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын 2019 оны 85 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаж төсвийн байгууллагуудыг тоолууржуулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх

ХОЁР. ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА ТАНАА:

1. Аймгийн ЭХЗЗ-д дутуу байгаа орон тооны бус гишүүнийг томилон ажиллуулж, хяналтын үр нөлөөг сайжруулж ажиллах

ГУРАВ. АЙМГИЙН ЗДТГ-ЫН СТСХ-ИЙН ДАРГА Ч.БАГДАЛ ТАНАА:

1. Халаалтын зардлыг төлөвлөхдөө халаалтын эзлэхүүний бодит тоо хэмжээ, батлагдсан үнэ тарифыг сайтар нягтлан үнэн зөв тооцож ажиллах.
2. Халаалтын зардлаас бусад зардал гүйлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох

ДӨРӨВ. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА:

1. Төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу сумдын ЗДТГ-т бүртгэлтэй уурын зуухны барилгыг түрээсийн төлбөргүйгээр ашиглаж байгаад хяналт хэрэгжүүлж, нэгдсэн арга зүйн зөвлөгөө хүргүүлэн, төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж ажиллах

Булган суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 7,829.9 сая төгрөгийн өртөг бүхий сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээний хөрөнгө оруулалтын ажлыг дээд шатны байгууллагад уламжлан өмчийг бүртгэлд тусган, ашиглагч байгууллагатай гэрээ байгуулах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлэхийг зөвлөмж өгсөн байгууллагуудад ирүүлнэ үү.

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/29

Ховд

**Аудитын тайлан
баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хүүлийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 2023 оны 10 дугаар сарын 5-ны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнд"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар илэрсэн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэд нийцлийн аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Г.Пүрэвганди), Засаг дарга (Э.Болормаа) болон холбогдох байгууллагуудад тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитын тайлангаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, үр дүнг 2024 оны 5 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Г.Пүрэвганди), Засаг дарга (Э.Болормаа) нарт зөвлөсүгэй.
4. Ажлын болон нотлох баримтын иж бүрдлийг ханган архивд хүлээлгэн өгөхийг аудитор (А.Нарандэлгэр), аудитор (Ц.Азаяа) нарт, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын багт хариуцуулсугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллахыг аудитын менежер (А.Цэцэгсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГУУДАА С ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР:


д/д	Санал ирүүлсэн байгууллагын нэр	Санал дугаар	Хариу тайлбар
1.	Ховд аймгийн ЗДТГ-ын СТСХ	1	Албан бичгээр зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллахаа илэрхийлсэн. Санал, тайлбаргүй тул тайлбар хүргүүлэх шаардлагагүй
2.	Ховд аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл	1	Тусгай зөвшөөрөл олголттой холбоотой тайлбар ирүүлсэн ч аудитаар ирүүлсэн баримт материал байхгүй тул хүлээн авах боломжгүй. Энэ асуудлаар аймгийн ЭХЗЗ-д албан шаардлага хүргүүлж байгаа болно.
		2	Үнэ тариф тогтоосон талаар тайлбар ирүүлсэн ч цахилгаан дулааны үнэ тариф тогтоох аргачлалыг мөрдөөгүй тул хүлээн авах боломжгүй. Энэ асуудлаар аймгийн ЭХЗЗ-д албан шаардлага хүргүүлж байгаа болно.
		3	Орон тооны бус гишүүн ажиллахгүй байгаа талаар тайлбар ирүүлсэн. Энэ асуудлаар өмнө хүргүүлсэн тайлангийн төсөлд ЭХЗЗ-д зөвлөмж өгсөн.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГУУДААС ИРҮҮЛСЭН САНАЛ:


 ХОВД АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГИЙН ГАЗАР
 84140 Ховд, Ховд аймаг
 Утас/факс: (+976)7043-2606
 Email: khovdmtg@khovd.gov.mn
 2023.11.20 № 51945
 Танаг 2023.11.13 № 355

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА Х.БОЛДБААТАР ТАНАА

Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудиттай танилцсан ба аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Ч.БАГДАЛ

84.001 2023/1089



ХОВД АЙМГИЙН
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ЮРЛЫГ

44000 Ховд, Ховд аймаг
Утас/факс: 7043 3002 http://www.khovd.gov.mn

2023-11-20 № 18

танай _____-ны № _____-т

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Х. БОЛДБААТАР
ТАНАА

Тайлбар хүргүүлэх тухай

Ховд аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлд танай аудитын код-2023/44-20 ШТА-ГА хийж, тайлангийн төсөл болон алдаа зөрчлийг илрүүлж тайлан ирүүлсэн тул тайлбар хүргүүлж байна.

Үүнд. 1. Эрчим хүчний зохицуулах зөвлөл нь дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл олгох, сунгахдаа Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үндсэн 10 үзүүлэлтээр баримт бичгийг бүрдүүлж авдаг. Гэтэл улсын болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд нь гүйцэтгэгч компаниудын гүйцэтгэл, болон хариуцлагаас хамаарч хангагч байгууллагадаа материалаа бүрдүүлж өгөөгүйгээс болж, аль аль талдаа хүндрэл үүсч байна.

2. Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 231 дүгээр тогтоолоор баталсан "Цахилгаан, дулааны үнэ тариф тогтоох аргачлал"-ыг мөрдөж тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн үнэ тарфын саналыг хянан хэлэлцэж, Засаг даргын зөвлөлийн хурлаар 2023 оны 05.06 дугаар саруудад олон удаа оруулж, хэлэлцүүлсэн боловч 2024 оны төсөвт зөвлөлийн баталсан үнэ тарифыг тусгах боломжгүй гэсэн хариу ирүүлсэн. Санхүү төрийн сангаас ирүүлсэн санал, тусгай зөвшөөрөл эзэмшигч 2 талын саналыг хэлэлцээд жигдхэн 30%-иар нэмэгдүүлэхээр шийдвэр гаргасан. Ер нь Эрчим хүчний тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн хүсэлтийг сар бүр хянаж батлах мөн үнэ тарифыг Хууль зүйн яам Захиргааны хэм хэмжээний актанд баталгаажуулсан тохиолдолд шууд мөрдөх журамтай юм.

3. Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны бус гишүүнээр ажиллаж байсан МХГ-ын эрчим хүчний улсын байцаагч Ш. Мөнхзаяа нь өндөр насны тэтгэвэрт гарсан, орных нь хүн томилогдоогүй түр тушаалтай хүн ажиллаж байсан гэтэл Мэргэлийн хяналтын газар татагдан буугдсан, байцагчийн эрхтэй мэргэжилтэн байхгүй байна.

ОРОН ТООНЫ ГИШҮҮН

Р. ЯНЖМАА

Хавсралт №1. Хэмжилтийн зөрүүний судалгаа

дд	Сумын нэр	Байгууллагын нэр	Барилгын эзлэхүүн		Зөрүү	
			Гэрээнд тусгасан	хэмжилтээр	Нэмэгдсэн	Буурсан
1	Зэрэг	ЗДТГ-ын байр	2387	3058	671	
2	Зэрэг	Сургууль	15430	16736	1306	
3	Зэрэг	Соёлын төв	1366	2056	690	
4	Зэрэг	Эмнэлэг	4606	3409		1197
5	Дарви	ЗДТГ-ын байр	2280	2741	461	
6	Дарви	Сургууль	14728	10941		3787
7	Дарви	Соёлын төв	3098	2650		448
8	Дарви	Эмнэлэг	4860	3985		875
9	Дарви	Цэцэрлэг	4010	3497		513
10	Цэцэг	ЗДТГ-ын байр	2360	2656	296	
11	Цэцэг	Сургууль	21119	16302		4817
12	Цэцэг	Соёлын төв	5945	5467		478
13	Цэцэг	Эмнэлэг	1686	1467		219
14	Цэцэг	Цэцэрлэг	3890	2150		1740
15	Булган	ЗДТГ-ын байр	2712	2923	211	
16	Булган	1-р Сургууль	26156.9	22021		4135.9
17	Булган	2-р Сургууль	26513.4	26212		301.4
18	Булган	Соёлын төв	6096	6350	254	
19	Булган	Эмнэлэг	14947.4	16462	1514.6	
20	Булган	1-р Цэцэрлэг	4128	4775	647	
21	Булган	2-р Цэцэрлэг	3225.8	2879		346.8
22	Булган	Спорт цогцолбор	6912	6298		614
23	Эрдэнэбүрэн	Соёлын төв	2618.85	1527.9		1090.95
24	Эрдэнэбүрэн	Дотуур байр	6293	2099.3		4193.7
25	Эрдэнэбүрэн	Спорт цогцолбор	4788	5098.8	310.8	
26	Дөргөн	Дотуур байр	1818.9	2383.5	564.6	
27	Дөргөн	ЗДТГ-ын байр	3476.4	2392.4		1084
28	Дөргөн	Цэцэрлэг	2160	1790.8		369.2
29	Жаргалант	9-р цэцэрлэг	5616	5616		0
30	Жаргалант	15-р цэцэрлэг	2308.8	1830.9		477.9
31	Жаргалант	14-р цэцэрлэг	2618	1786.9		831.1
32	Жаргалант	11-р цэцэрлэг	3398	1423.4		1974.6
33	Жаргалант	Цаст-Алтай сургууль	24151.3	24284.8	133.5	
34	Жаргалант	7-цэцэрлэг	2948	1002.51		1945.49
35	Үенч	Соёлын төв	7208	6048		1160
36	Ховд	Соёлын төв	2618.85	1527.9		1090.95
Дүн			254018.6	227388.11	7059.5	33689.99

Хавсралт №2. Дулаан халаалтын батлагдсан төсөв, гэрээний дүнгийн харьцуулсан судалгаа 2022 он. сая.төг

№	Сумын нэр	Дулаан нийлүүлэгч компанийн нэр	Суурь үнэ төгрөгөөр /НӨАТ-тай/	Тамгын газар			ЕБСургууль			СӨБоловсрол			Соёлын байгууллага			Эрүүл мэндийн төв			НИЙТ		
				Төлөвлөсөн	Гэрээнд тусгасан	Зөрүү	Төлөвлөсөн	Гэрээнд тусгасан	Зөрүү	Төлөвлөсөн	Гэрээнд тусгасан	Зөрүү	Төлөвлөсөн	Гэрээнд тусгасан	Зөрүү	Төлөвлөсөн	Гэрээнд тусгасан	Зөрүү	Төлөвлөсөн	Зөрүү	Гэрээнд тусгасан
1	Алтай	Тоосгон уул ХХК	1595	35	35	0.2	278.1	196.8	81	30	24	6.2	23	30	7.5	24	30	-6	390.7	316.5	74
2	Буянт	Жаргалант Буд Трейд	1595	13	13	0	33.8	33.8	0	15	15	0	17	17	0	16	16	0	94.4	94.4	0
3	Дарви	Тоосгон уул ХХК	1485	26	24	2	174	174.9	0.9	40	42	1.3	32	32	0	46	58	12	318.5	330.2	-12
4	Дөргөн	Жигүүрт ажнай ХХК	1595	28	28	0	186.7	186.7	0	28	28	0	66	66	0	59	59	0	366.8	366.8	0
5	Дуут	Эрдэс тайга ХХК	1595	27	26	0.5	149.9	149.9	0	32	32	73	73		73	28	36	7.1	310.2	211.5	99
6	Зэрэг	Улсын төсвөөр	1485	25	23	2	163.1	166.6	3.5	42	46	4.4	13	13	0.2	22	23	1.7	263.4	271.2	7.8
7	Манхан	Эрчим дөл ХХК	1449	40	51	12	232.4	238.1	5.7	64	72	8.4	89	137	###	31	30	0.3	455.1	528.4	-73
8	Мянгад	Тоосгон уул ХХК	1595	67	61	5.2	165.1	131.4	34	51	58	7.3	54	54	0.2	19	19	0	355.3	323.9	31
9	Мөнххайрхан	Солонго талст ХХК	1595	26	33	7.7	87.8	156.5	69	28	37	8.7	54	121	-31	19	24	5.3	213.7	371	157
10	Үенч	Тоосгон уул ХХК	1595	29		29	302.2	302.2	0	55	55	0	33	81	-48	38	40	1.2	456.8	476.7	-20
11	Ховд	Вива зон ХХК	1595	36	35	0.8	194.9	292.5	98	21	32	11	9.7	63	-53	11	29	18	272.2	450.9	179
12	Цэцэг	Эрчим дөл ХХК	1485	24	25	0.6	245.9	250.9	-5	51	46	4.3	80	62	18	20	0.1	420.2	403.5	17	
13	Чандмань	Тоосгон уул ХХК	1540	39	39	0	204.9	204.9	0	43	43	0	33	33	0.2	39	43	4.3	357.3	361.8	4.5
14	Эрдэнэбүрэн	Вива зон ХХК	1595	43	66	24	193.3	194.7	1.4	29	32	2.4	101	86	15	27	25	1.9	392.3	402.7	-10
НИЙТ ДҮН				455	458	3.4	2612.1	2679.9	68	527	528	1.4	676	793	-81	398	451	53	4666.9	4909.5	243

Хавсралт №3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үнэ тарифын судалгаа

№	ААНБайгууллагын нэр	Үйлчилгээ үзүүлж буй сумдын нэр	Суурьлагдсан хүчин чадал/МВт/	Хөшөөтийн уурхайгаас нүүрс тээвэрлэх зай /км/	2022 мөрдөж буй тариф			2023 ТЗЭ-с ирүүлсэн санал			2023 оны 33-ийн баталсан тариф			Өмнөх оноос нэмсэн хувь
					Төсөвт газрууд төг/м³	ААНБ төг/м³	Төсөвт газрууд төг/м³	Төсөвт төг/м³	ААНБ төг/м³	Айл өрх төг/м²	Төсөвт газрууд төг/м³	ААНБ төг/м³	Айл өрх төг/м²	
1	Тоосгон уул ХХК	Мянгад	2.6	248	1450	1450		2046			1885	1450	900	30%
2	Тоосгон уул ХХК	Алтай	2.8	210	1450	1450		2084			1885	1450	900	30%
3	Эрчим дөл ХХК	Манхан	3.4		1350	1350		2115	1485		1755	1350	900	30%
4	Эрчим дөл ХХК	Цэцэг	1.4	30	1350	1350		2115	1485		1755	1350	900	30%
5	Вива зоне ХХК	Эрдэнэбүрэн	1.2	270	1450	1450		2240	1450	1200	1885	1450	900	30%
6	Вива зоне ХХК	Ховд	1.2	220	1450	1450		2200	1450	1200	1885	1450	900	30%
7	Эрдэс тайга ХХК	Дуут	1.2	280	1450	1450	900	2235		900	1885	1450	900	30%
8	Эрдэс тайга ХХК	Чандмань	2.65	150	1400	1400		1996			1820	1400	900	30%
9	Жилүүрт ажнай ХХК	Дөргөн	3.8	300	1450	1450		2298			1885	1450	900	30%
10	Цахиур илч ХХК	Дарви	1.45	60	1350	1350		2250			1755	1350	800	30%
11	Мянган сугайн буян Хөшөөт баг	Цэцэг	0.8	30	1320	1320		1800			1716			
12	Мирай Кэнсэцу ХХК	Үенч	1.45	260	1450	1450	900	1989		900	1885	1450	900	30%
13	Солонго талст ХХК	Мөнххайрхан	2.65	190	1450	1450	900	2044		1000	1885	1450	900	30%
14	Тээлийн илч ОНӨҮГ	Зэрэг	3	65	1350	800	400	1920	800	600	1755	800	600	30%
15	Булган түшиг	Булган	6	300	1390	1390	800	1950	1390	800	1807	1390	800	30%